

Форексийн шилдэг 5 индикатор ба тэдгээрийн хэрэглээ

1. Moving Averages

Төрөл: *Хандлага дагах*

Оновчтой хэрэглээ: *Бусад индикатортай хослуулан хэрэглэх*

Энгийн шилжих дундаж нь ханшийн тодорхой хугацааны дундаж утгыг тооцоолон гаргадаг. Шилжих дунджийг гол төлөв ханшийн хандлагыг тодорхойлоход болон хугарлын худал дохиог бууруулах болон шуугианыг багасгахад ашигладаг. Шилжих дунджийн индикаторыг хэрэглэхдээ бусад шинжилгээний багажтай хослуулан ашиглах нь оновчтой байдаг. Жишээлбэл, 50 өдрийн шилжих дундаж 200 өдрийн шилжих дунджийг дээш огтлон гарах үзэгдлийг “Golden Cross”(Алтан Огтлолцол) гэж үздэг ба богино хугацааны 50 өдрийн шилжих дундаж урт хугацааны 200 өдрийн шилжих дунджийн дээр гарснаар ханшийн дээш чиглэсэн “Momentum”(Инерц) баталгааждаг. Эсрэг тохиолдлыг буюу 50 өдрийн шилжих дундаж 200 өдрийн шилжих дунджийг доош огтлон гарах үзэгдлийг “Death Cross”(Үхмэл Огтлолцол) гэх ба ханшийн үйл хөдлөлийн инерц буурах чиглэлд байгааг харуулна. Шилжих дунджийг тооцоолох төрөл бүрийн аргачлал байдаг хэдий ч валютын зах зээлийн техник шинжилгээнд Шилжих Дундаж буюу “MA”¹, Экспоненциал Шилжих Дундаж буюу “Exponential Moving Average”(EMA), Жигнэсэн Шилжих Дундаж буюу “Weighted Moving Average”(WMA), Шугаман Жигнэсэн Шилжих Дундаж буюу “Linear Weighted Moving Average”(LWMA), Тэгшитгэсэн Шилжих Дундаж буюу “Smoothed Moving Average”(SMMA),... гэх мэт аргачлалуудыг өргөн хэрэглэдэг. Шилжих дунджийн огтлолцлыг харуулсан дараах жишээнүүдийг харна уу



Зураг 1: “EURUSD” хослолын чартад 50 “SMA” шулуун 200 “SMA” шулууныг доош сэтэлсэн байгаа ба үхмэл огтлолцол үүсгэжээ. Хани 50 SMA шулуунд буцаж ирэхээс өмнө ойролцоогоор 200 pip унасан харагдаж байна.

1 “SMA”(Simple Moving Average) буюу Энгийн Шилжих Дундаж гэж нэрлэх нь бий.



Зураг 2: EURJPY хослолын чартад 50 SMA шулуун 200 SMA шулууныг дээш огтлон гарснаар алтан огтлолцол үүсэж бух хандлагыг зааж байна. Хани 50 SMA шулуунд буцаж ирэхийнхээ өмнө 500 орчим pipээр өссөн үзүүлэлттэй байна.

2. MACD (Moving Average Convergence Divergence)

Төрөл: Хандлагын хүч/Шинэ хандлага

Оновчтой хэрэглээ: Бусад багажуудтай хослуулан хэрэглэх

“MACD”(Шилжих Дунджийн Конвергенц/Дивергенц) индикаторыг арилжааны ямар нэг дохиог баталгаажуулахад хэрэглэвэл хамгийн тохиромжтой. Өөрөөр хэлбэл бусад индикатор буюу шинжилгээний багажуудтай хослуулан хэрэглэх нь зүйтэй. “MACD” нь 3 үндсэн параметртэй ба тэдгээр нь 12 үеийн “Fast EMA”(тухайн агшнаас өмнөх 12 лааны хурдан экспоненциал шилжих дунджаар), 26 үеийн “Slow EMA”(тухайн агшнаас өмнөх 26 лааны удаан экспоненциал шилжих дундаж) болон 9 үеийн “MACD SMA”(хоёр шилжих дунджийн зөрөөний 9 лааны энгийн шилжих дундаж ба гистограммаар дүрслэгддэг)² болно. Шилжих дунджийн огтлолцлын аргатай адил гистограмм болон дохионы шулуун хоёрын огтлолцлоор хандлага тодорхойлох ба гистограмм “0” төвшний хаана байгаагаар баталгаажуулна.



Зураг 4: “AUDJPY” чартад харагдаж байгаагаар “MACD”-ийн эхний бух огтлолцлоор шинэ хандлага эхэлж байгааг сануулсан ба дараад нь 200 болон 50 үеийн “SMA” огтлолцсоноор шинэ хандлага баталгаажиж байна. Хожим нь “MACD” “0” төвшинөөс дээгүүр дахин бух огтлолцол хийж өсөх хандлагыг бүрэн баталгаажуулсан байна.

3. RSI (Relative Strength Index)

Төрөл: **Overbought/Oversold төвшний хэмжүүр**

Оновчтой хэрэглээ: **Орой/Ёроолыг барьж авах болон Авах ашгийн төвшинг тодорхойлох**

“RSI”(Харьцангуй Хүчний Индекс) нь “Stochastic Oscillator”(Стохастик Осцилятор)-той төстэй индикатор ба 0 – 100 хооронд ханш дагадаг осцилятор юм. “RSI”-д 70%-100% хооронд “Upper overbought zone”(Хэт худалдан авалт хийгдсэн дээд бүс), 0%-30% хооронд “Lower oversold zone”(Хэт худалдагдсан доод бүс) болон 30%-70% хооронд дундын буюу “Neutral zone”(Завсрын бүс) гэсэн үндсэн гурван бүс байдаг. Бид зах зээлийн хэт худалдан авагдсан эсвэл худалдагдсан нөхцөл байдалд үндэслэн боломжит орой болон ёроолыг барьж авахад эдгээр бүсүүдийг хэрэглэж болно. RSI-аар орой болон ёроолыг тодорхойлохоос гадна ханшийн хандлага тодорхойлох болон баталгаажуулж болно. Дараах жишээнүүдийг үзнэ үү.



Зураг 5: "EURUSD" чартад "RSI" импульс хэлбэртэй явсаар 30% бүсийн доогуур ороход зах зээлд худалдагч үлдээгүйг илтгэнэ. Улмаар хани эргэж бух чиглэлд орсон байна. Энэ үзэгдэл хоёр удаа давтагдсан байгаа нь индикатор хэр үр дүнтэйг харуулж байна.



Зураг 6: "GBPUSD" шинэ орой(High) хийсний дараа "RSI" хэт худалдан авалт хийгдсэн бүсэд байгаа нь унах магадлалыг харуулж байна. Бидний харж байгаагаар баавгай хандлага ханшийг 500 орчим pip унах хүртэл худалдагчидыг арилжаанд байлгасаар байна.

4. Bollinger Band

Төрөл: *Савалгаа хэмждэг*

Оновчтой хэрэглээ: *Хани нягтран хугарал үүсэх үед*

Боллинжерийн Тууз нь дээд тууз, дунд тууз, доод туузаас бүрддэг. Боллинжерийн тууз нарийсаж, цар хүрээ нь багасахад ханшийн савалгаа багасдаг ба тууз өргөсөхийн хэрээр тухайн хослолд хийгдэх арилжаа өсөн нэмэгдэж их хэмжээний мөнгө эргэлддэг байна. Арилжааны төлөвлөгөөндөө боллинжерийн туузыг хэрхэн хэрэглэхээс шалтгаалан өөр өөр аргачлал байдаг. Жишээ зургийг харна уу.

Боллинжерийн Ойлт



Зураг 7: Арилжаа эрхлэгчид боллинжерийн туузын оргил эсвэл ёроолоос урт, богино позиц эрэх боломжтой. Энэ аргачлалыг хани ямар нэг хандлагад захирагдаагүй үед хэрэглэвэл тохиромжтой. Туузаас хани хэрхэн ойж байгааг лааны утаснаас харна уу.

Боллинжерийн Шахалт



Зураг 8: Нэг талдаа шахагдсан туузын хамт бид түрэмгийлсэн лааны шинжтэй хугаралыг ч мөн харж болно. Хани дээд туузыг дээш сэтэлж, үргэлжлүүлэн өссөн байгаа ба эндээс арилжаа эрхлэгч хугарлыг эрт барьж авах боломж олддог.

5. Parabolic SAR

Төрөл: Хандлагын төгсгөлийг таних

Оновчтой хэрэглээ: Арилжаанаас гарах/Stop Loss байрлуулахад

“**Parabolic Stop And Reverse**”(Парабол ЗБЭ³) нь хэрэглэхэд хялбар багаж ба цэгүүд лааны доор гарвал урт арилжааны дохио, дээр гарсан үед богино арилжааны дохиог тус тус өгдөг. Парабол ЗБЭ-ийг бусад шинжилгээний багажуудтай хослуулан хэрэглэвэл тохиромжтой ба ханш савалгаа ихтэй үед хэрэглэхээс зайлсхийх хэрэгтэй. Энэхүү индикаторыг ханш тодорхой хандлага үүсгэн хөдөлж байх үед хэрэглэвэл хамгийн тохиромжтой.



Бичсэн,

Кристофер Родригүз(Christopher Rodriguez), Ахлах Валютын Стратегич(Chief Currency Strategist)

Врайт Тайм Капитал Групп(Wright Time Capital Group)

Твиттер хаяг: @niceatfx

Цахим хаяг: <http://www.globalfxclub.com/forex-education/347-top-10-forex-indicators-and-how-to-use-them>

Орчуулсан,

Э. Батмандах

3 Жэй. Вейллэс Вайлдер(J. Welles Wilder) Парабол ЗБЭ(Парабол Зогсолт Ба Эргэлт) зохиосон ба ханшийн хандлагын эргэлтийг танихад зориулагдсан аргачлал юм.